

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИМГИЙН
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЭЛТ

ТТ 8
 02

Дугаар 66/
 2018

Улаанбаатар-15171
 Утас: 323022 328097
 Факс: 976-11-20338

Объектын нэр:	“120 хүүхдийн цэцэрлэг, 180 сурагчтай бага сургуулийн цогцолбор барилга”-ын ажлын зураг төсөл, төсөв Шифр: GRD-17/06-A-003
Объектын байршил:	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн 7, 8, 9 баллын бүсэд баригдах жишиг барилга / Нэг маягийн зураг төсөл/
Хүчин чадал:	“А” блок нь тэнхлэгээрээ 23.6 м х 12.6 м хэмжээтэй, зоорьгүй, 3 давхар барилга, “Б” блок нь тэнхлэгээрээ 34.1 м х 15.6 м хэмжээтэй зоорьгүй, 2 давхар барилга, “В” блок нь тэнхлэгээрээ 18.0 м х 12.0 м хэмжээтэй зоорьгүй, 2 давхар барилга
Захиалагч:	“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ
Санхүүжилтийн эх үүсвэр:	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр	“Гандирс Орд” ХХК
Регистрийн дугаар:	РД: 2095408
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2017.07.07
Ажилбарын төрөл:	1.2.2, 1.1.1, 1.1.2 заалтын дагуу
Зураг төсөл боловсруулах үндэслэл:	
Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо:	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн “Бага сургуулийн барилгын байршил тогтоох тухай” 9/35 дугаар тогтоол Нийслэлийн засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/350 дугаар захирамж Газрын зөвшөөрлийн дагуу сонгосон байршилд байршуулах
Архитектур төлөвлөлтийн даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Улаанбаатар хотын Ерөнхий архитектор бөгөөд Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын даргын 2017 оны 06-р сарын 14-ний өдөр баталсан эскиз зураг “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын даргын 2015 оны 10-р сарын 26-ны өдөр баталсан 39/2015 тоот “Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга”-ын зураг төсөл боловсруулах даалгавар “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дарга, НЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга болон “Гандирс Орд” ХХК-ийн захирал нарын хооронд 2017 оны 02-р сарын 17-ны өдөр байгуулсан НХОГ-2017/ЗҮ-БСЦ-03 тоот зураг төсөл боловсруулах гэрээ сунгалт-2



Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн 7, 8, 9 баллын бүсэд баригдах жишиг барилга /нэг маягийн зураг төсөл/
 “120 хүүхдийн цэцэрлэг, 180 сурагчтай бага сургуулийн цогцолбор барилга”-ын ажлын зураг төсөл, төсөв

Техникийн нөхцөлүүд:			
Техникийн нөхцөлүүд:	Олгосон байгууллага	Дугаар, огноо	Хүчинтэ й байх хугацаа
Дулаан хангамж:	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн “Бага сургуулийн барилгын байршил тогтоох тухай” 9/35 дугаар тогтоолыг үндэслэн давтан хэрэглэгдэх нэг маягийн зураг төслийг заасан байршилд тохируулан инженерийн хангамжийн эх үүсвэрийг шийдвэрлэх		
Цахилгаан хангамж:			
Ус хангамж, ариутгах татуурга			
Гадна холбоо:			
Зөвшөөрөлцсөн байгууллагууд:			
Улаанбаатар хотын Ерөнхий архитектор бөгөөд Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын дарга			Э.Анар
Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга, Хурандаа			Ж.Чүлтэмсүрэн
Зураг төслийн бүрэлдэхүүн:			
Зургийн бүрдэл:	Зураг төслийн гүйцэтгэсэн байгууллагын нэр	Шалгасан экспертийн нэр	
Барилга архитектур:	“Гандирс Орд” ХХК	Ш.Сумъяа	
Барилга бүтээц:	“Гандирс Орд” ХХК	Ц.Ганболд	
Халаалт, агаар сэлгэлт:	“Түмэн амгалан ордон” ХХК	Б.Лхамхүү	
Цэвэр, бохир ус:	“Санни сервис” ХХК	М.Эрдэнэцэцэг	
Дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж:	“Ти энд И” ХХК	Д.Гягар	
Дотор холбоо, дохиолол:	“Ти энд И” ХХК	Ц.Баярбилэг	
Төсөв:	“ХБХДТ” ХХК	Д.Санж	
Инженер геологи:	-	-	
Ерөнхий дүгнэлт: /Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлээс/			
Барилга байгууламжийн техникийн ерөнхий өгөгдлийн болон техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт:	Барилга байгууламжийн ерөнхий өгөгдөл: Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт баригдах жишиг барилга “120 хүүхдийн цэцэрлэг, 180 сурагчтай бага сургуулийн цогцолбор барилга”-ын ажлын зураг төслийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн “Бага сургуулийн барилгын байршил тогтоох тухай” 9/35 дугаар тогтоол, “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын даргын 2015 оны 10-р сарын 26-ны өдөр баталсан 39/2015 тоот “Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга”-ын зураг төсөл боловсруулах даалгавар, “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дарга, НЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга болон болон “Гандирс Орд” ХХК-ийн захирал нарын хооронд 2017 оны 02-р сарын 17-ны өдөр байгуулсан НХОГ-2017/ЗҮ-БСЦ-03 тоот зураг төсөл боловсруулах гэрээ сунгалт-2-ыг үндэслэн “Гандирс Орд” ХХК-д давтан хэрэглэгдэх нэг маягийн зураг төслийг боловсруулсан байна.		

Байгаль цаг уурын өгөгдөл:

Гадна агаарын температур -39.0°C

Цасны ачаалал 50 кг/м^2

Салхины дундаж хурд 35 кг/м^2

Газар хөдлөлтийн балл 7, 8 балл

Барилгын буурь хөрсний үзүүлэлт:

Суурь суух буурь хөрсний үзүүлэлтийг төлөвлөгдсөн байршил бүрт зориулан хийгдсэн инженер геологийн судалгааны дүгнэлтийг үндэслэн дахин тооцох шаардлагатай. Давтан хэрэглэгдэх зураг төсөлд буурь хөрсийг загварчлан бор шаргал өнгөтэй, бага чийгтэй, элсэнцэр чигжээстэй сайр сайрган ул хөрс гэж тооцсон байна.

Суурь суух буурь хөрсний механик чанарын үзүүлэлт нь:

Барьцалдах хүч: $C^II=1.3 \text{ кПа}$

Дотоод үрэлтийн өнцөг: $\Phi^H=36^{\circ}$

Хэв гажилтын модуль: $E_n=45 \text{ мПа}$

Тооцооны эсэргүүцэл: $R_0=600 \text{ кПа}$

Хөрсний усны түвшин -2.5 м -3.7 м -т тогтсон

Хөрсний улирлын хөдлөлтийн норматив гүн 3.51 м

Газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд - III

Барилга байгууламжийн төлөвлөлт, хүчин чадал:

"А" блок нь тэнхлэгээрээ $23.6 \text{ м} \times 12.6 \text{ м}$ хэмжээтэй, зоорьгүй, 3 давхар барилга, "Б" блок нь тэнхлэгээрээ $34.1 \text{ м} \times 15.6 \text{ м}$ хэмжээтэй зоорьгүй, 2 давхар барилга, "В" блок нь тэнхлэгээрээ $18.0 \text{ м} \times 12.0 \text{ м}$ хэмжээтэй зоорьгүй, 2 давхар барилга байхаар тус тус төлөвлөсөн байна.

Цэцэрлэг сургуулийн орцны хэсэгт "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага" /БД 31-101-04/, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчин шаардлагад нийцсэн зураг төсөл зохих дүрэм" /БД 31-112-11/-ийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж налуу зам төлөвлөсөн байна.

"А" блок сургуулийн 1, 2-р давхарт:

Эмчийн өрөө, хичээлийн ангиуд, аж ахуйн өрөөнүүд, хүнсний агуулах, ариун цэврийн өрөөг,

"Б" блок цэцэрлэгийн 1, 2-р давхарт:

Бүлгийн хувцас солих өрөөнүүд, цагаан хэрэглэлийн агуулах, цагаан хэрэглэлийн угаалгын өрөө, бүлгийн өрөөнүүд, хүнсний агуулах, ариун цэврийн өрөөнүүд, цахилгаан, холбоо, дулааны техникийн өрөө, заах аргын кабинет, эмчийн өрөө, туслах өрөө, дуу хөгжмийн танхим, аж ахуйн өрөөнүүдийг,

"В" блокын 1, 2-р давхарт:

Хооллох танхим, халуун цех, спорт заал, ариун цэврийн өрөөг тус тус төлөвлөсөн байна.



Барилгын үндсэн бүтээц нь:

Суурь: Цутгамал төмөр бетон баганан суурьтай, цутгамал төмөр бетон суурийн дам нуруутай, гадна ханын доор цутгамал бетон шугаман суурьтай,

Даацын үндсэн бүтээц нь: Цутгамал төмөр бетон арагт бүтээцтэй,

Гадна хана: 1-р давхрын гадна хана 360 мм-ийн зузаан хөнгөн блокон дүүргэгч ханатай, 150 мм-ийн зузаан хөөсөнцөр дулаалгатай, 120 мм-ийн зузаан ердийн тоосгон өнгөлгөөтэй, 2, 3-р давхрын гадна хана 360 мм-ийн зузаан хөнгөн блокон дүүргэгч ханатай, 150 мм-ийн зузаан хөөсөнцөр дулаалгатай, тортой шавардлага өнгөлгөөтэй,

Хучилт: Цутгамал төмөр бетон хучилттай,

Дээвэр: Спорт заал нь төмөр дам нуруутай 200 мм зузаан сэндвичэн хавтан дээвэртэй, сургууль, цэцэрлэг нь дулаалгатай цутгамал төмөр бетон хавтгай дээвэртэй байхаар тус тус төлөвлөжээ.

Халаалт агаар сэлгэлт:

Дулаан хангамжийн эх үүсвэр нь төвлөрсөн сүлжээнээс хангахаар төлөвлөсөн байна. Халаалтын системд доогуур түгээлттэй 2 хоолойт мухардмал эргэлттэй систем төлөвлөсөн байна. Агаар сэлгэлтийн ердийн болон механик систем төлөвлөсөн байна.

Дулаан зөөгчийн температур $90^{\circ}\text{C}/70^{\circ}\text{C}$,

Хашлага хийцийн дулаан дамжуулалтын коэффициент: $K_x=0.19 \text{ Вт}/\text{м}^2\text{C}$, $K_{xy}=0.17 \text{ Вт}/\text{м}^2\text{C}$, $K_d=1.82 \text{ Вт}/\text{м}^2\text{C}$, $K_{хаал}=1.82 \text{ Вт}/\text{м}^2\text{C}$

Дулааны ачаалал: $Q_{ха}=138680 \text{ Вт}$, $Q_{х.ус}=81000 \text{ Вт}$, $Q_{бүгд}=219685 \text{ Вт}$

Цэвэр, бохир ус:

Барилгын ус хангамжийн системийг төвийн төвлөрсөн сүлжээнээс хангахаар төлөвлөсөн байна. Ус хангамжийн системийг цайрдсан ган хоолойгоор, салбар шугамуудыг хуванцар хоолойгоор угсрахаар зураг төсөлд тусгасан байна. Ариутгах татуургын шугамыг өөрийн урсгалаар төвийн сүлжээнд зайлуулагдахаар төлөвлөсөн байна.

Цэвэр, бохир усны тооцоо: $q_{бүгд}=10.02 \text{ м}^3/\text{хон}$,

$q_{ху}=6.55 \text{ м}^3/\text{хон}$, $q_{хал}=3.65 \text{ м}^3/\text{хон}$, $q_{бох}=10.02 \text{ м}^3/\text{хон}$

Дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж:

Тус барилга нь цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааны II зэрэгт хамрагдах тул тэжээлийг гүн газардуулсан нейтральтай бие биеэ нөөцлөх хос кабель шугамаар өгөх ба оролтондоо гар сэлгэн залгагчтай байхаар төлөвлөсөн байна.

Газардуулгын эсэргүүцэл 4 Ом-оос хэтрэхгүй байна.

Цахилгааны ачаалал:

Цахилгааны оролт 1: $P_c=74.64 \text{ кВт}$, $P_r=62.33 \text{ кВт}$, $I_r=129.1 \text{ А}$

Цахилгааны оролт 2: $P_c=58.58 \text{ кВт}$, $P_r=46.64 \text{ кВт}$,

	<p>$I_T=74.68 \text{ A}$ Сүлжээний хүчдэл 220В байна. Холбоо дохиолол: Барилгын холбоо дохиоллын системд суурин телефон, интернет сүлжээ, кабелийн телевиз, хяналтын систем, галын дохиолол, зарлан мэдээлэх систем, завсарлагааны хонхны систем зэргийг төлөвлөсөн байна.</p>
<p>Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаархи тодорхой санал, дүгнэлт:</p>	<p>Зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдлийг холбогдох орон тооны бус экспертүүд шалгаад: Барилга архитектор: Экспертийн өгсөн зөвлөмжийн дагуу зураг төсөлд засвар өөрчлөлт оруулсан байна. Барилга бүтээц: Экспертийн өгсөн зөвлөмжийн дагуу зураг төсөлд засвар өөрчлөлт оруулсан байна. Халаалт агаар сэлгэлт: Экспертийн өгсөн зөвлөмжийн дагуу зураг төсөлд засвар хийсэн бөгөөд халаалтын системийн зураг төсөл нь норм дүрмийн шаардлага хангасан гэж дүгнэсэн байна. Цэвэр, бохир ус: Экспертийн өгсөн зөвлөмжөөр ажлын зураг төсөлд засвар хийсэн бөгөөд холбогдох норм ба дүрмийн шаардлага хангасан гэж дүгнэсэн байна. Дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж: Экспертийн өгсөн зөвлөмжийн дагуу зураг төсөлд засвар өөрчлөлт оруулсан байна. Дотор холбоо дохиолол: Дотор холбоо дохиоллын зураг төсөл нь инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэлтэй уялдсан гэж дүгнэсэн байна. Төсөв: Эксперт нь "Барилгын материал бүтээц эдлэлийн үнийн лавлах" /БД 81-109-16/-ийн дагуу төсөвт өртгийг хянасан байна.</p>
<p>Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан гаргасан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаархи дүгнэлт.</p>	<p>Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт "120 хүүхдийн цэцэрлэг, 180 сурагчтай бага сургуулийн цогцолбор" барилга" баригдсанаар нийслэлийн хэмжээнд хүүхдийн цэцэрлэг, бага сургуулийн хүчин чадал нэмэгдэж хүүхдүүдийн сурч боловсрох таатай орчин нөхцөл бүрдэх юм.</p>

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн 7, 8, 9 баллын бүсэд баригдах жишиг барилга
/нэг маягийн зураг төсөл/
"120 хүүхдийн цэцэрлэг, 180 сурагчтай бага сургуулийн цогцолбор барилга"-ын ажлын зураг төсөл, төсөв

Төсөвт өртөг: Газар хөдлөлтийн 7, 8 баллын бүсэд

№	Ажлын төрөл	Барилгын ажил	Тоног төхөөрөмж	Нийт өртөг	
а. Барилгын ажил					
1	Барилга угсралт	1,656,537,764.0	-	1,656,537,764.0	
2	Халаалт, агаар сэлгэлт	151,958,021.0	9,470,000.0	161,428,021.0	
3	Цэвэр бохир ус	47,114,829.0	-	47,114,829.0	
4	Дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж	94,097,119.0	-	94,097,119.0	
5	Дотор холбоо дохиолол	40,558,932.0	-	40,558,932.0	
6	Талбайн тохижилт	202,208,873.0	-	202,208,873.0	
7	Бусад зардал	334,255,333.0	-	536,464,206.0	
	Нийт төсөвт өртөг:	2,526,730,871.0	9,470,000.0	2,536,200,871.0	
Төсөвт өртгийн нэгж хүчин чадал					
№	Ажлын төрөл	Барилгын ажил	Хүчин чадал /м ² /	Нэгж өртөг	Жишиг үнэлгээний нэгж өртөг /сая.төг/
а. Барилгын ажил					
1	Барилга угсралт /м ² /	2,536,200,871.0	2278,18	1,113,257.0	1,529,960.0

Төсөвт өртөг: Газар хөдлөлтийн 9 баллын бүсэд

№	Ажлын төрөл	Барилгын ажил	Тоног төхөөрөмж	Нийт өртөг	
а. Барилгын ажил					
1	Барилга угсралт	1,684,563,203.0	-	1,684,563,203.0	
2	Халаалт, агаар сэлгэлт	151,958,021.0	9,470,000.0	161,428,021.0	
3	Цэвэр бохир ус	47,114,829.0	-	47,114,829.0	
4	Дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж,	94,097,119.0	-	94,097,119.0	
5	Дотор холбоо дохиолол	40,558,932.0	-	40,558,932.0	
6	Талбайн тохижилт	202,208,873.0	-	202,208,873.0	
7	Бусад зардал	338,509,596.0	-	338,509,596.0	
	Нийт төсөвт өртөг:	2,559,010,571.0	9,470,000.0	2,568,480,571.0	
Төсөвт өртгийн нэгж хүчин чадал					
№	Ажлын төрөл	Барилгын ажил	Хүчин чадал /м ² /	Нэгж өртөг	Жишиг үнэлгээний нэгж өртөг /сая.төг/
а. Барилгын ажил					
1	Барилга угсралт /м ² /	2,568,480,571.0	2278,18	1,127,426.0	1,529,960.0

Эксперт нь: Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн 7, 8 баллын бүсэд баригдах "120 хүүхдийн цэцэрлэг, 180 сурагчтай бага сургуулийн цогцолбор барилга"-ын ажлын төсөвт өртгийг **2 536 200 871.0** /хоёр тэрбум таван зуун гучин зургаан сая хоёр зуун мянга найман зуун далан нэгэн/ төгрөгөөр, газар хөдлөлтийн 9 баллын бүсэд баригдах "120 хүүхдийн цэцэрлэг, 180 сурагчтай бага сургуулийн цогцолбор барилга"-ын ажлын төсөвт өртгийг **2 568 480 571.0** /хоёр тэрбум таван зуун жаран найман сая дөрвөн зуун наян мянга таван зуун далан нэгэн/ төгрөгөөр тус тус хянасан байна.

"Барилгын тухай" Монгол Улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т "барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх", 38.1.3-т "зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх", 39.4-т "Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээх", 39.5-д заасны дагуу "Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаархи дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ".

Тус зураг төсөл нь Нийслэлийн Онцгой байдлын газрын 2017 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн Барилгын зураг төсөлд хяналт хийсэн тухай 10/641 тоот дүгнэлтээр хянагдсан байна.

Сонгосон байршилд гадна дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуурга, гадна холбоо, гадна цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг хангагч байгууллагуудаас авах шаардлагатай бөгөөд зураг төслийг олгогдсон техникийн нөхцөл болон барилгын норм ба дүрмийн дагуу боловсруулан, холбогдох байгууллагуудтай зөвшилцөж магадлал хийлгэх шаардлагатай.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн 7, 8, 9 баллын бүсэд баригдах жишиг барилга /нэг маягийн зураг төсөл/ "120 хүүхдийн цэцэрлэг, 180 сурагчтай бага сургуулийн цогцолбор барилга"-ын ажлын зураг төсөл, төсөвт "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм", "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм" /БНБД 81-94-12/, "Барилгын төсөв зохиох дүрэм" /БНБД 81-95-12/, "Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын даргын 2017 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 3/2702 тоот албан бичгийг тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, ерөнхий дүгнэлт бичсэн болно.

Ерөнхий дүгнэлт нь экспертүүдийн **15** хуудас магадлалын хавсралт дүгнэлтийн хамт хүчинтэй.

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД
МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН:**

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ
МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ
МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ц.АМАРСАНАА

Э.ХАНГАЛ

Г.САРУУЛТУЯА